



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2019 \* 5 сар | Дугаар 7

MONDAY 2019  
FRONTIER  
FINTECH  
SUMMIT

# FRONTIER FINTECH SUMMIT 2019

Ерөнхий зохион байгуулагч:  
Монголын Санхүүгийн Технологийн Холбоо  
Хамтран зохион байгуулагч:  
Гадаад Харилцааны Яам, Санхүүгийн Зохицуулах Хороо

5 сарын 9
Frontier Fintech Hackathon  
HUB инновацийн төвд

5 сарын 10
Policy & Regulation  
дугуй ширээний хэлэлцүүлэг  
Гадаад Харилцааны яаман дээр

5 сарын 11
Frontier Fintech Summit  
Шангрила Ball room-д

Chairperson

CEO and President of Azimo Group  
**Gerelma Batkhazan**

Keynote Speakers

Minister of Culture, Arts and Young Affairs  
**Tsogbaatar Davdla**

Chairman, FIC  
**Davaasambay Ochirbador**

Head of Digital Hong Kong, Chief  
Data and Officer  
**Charles Hodgkinson**

APAC CEO, Chairman, ICT Task and  
Blockchain Commission Chair, Director  
**Nam Sangyul**

Deputy Minister of Finance  
**Baigantsaga Khambuaatar**

Chairman of Hong Kong Commission of  
Financial Regulation of Hong Kong  
**Shen Wai-U Tang**

Founder & CEO, Credit Realty, Inc.  
**Takashi Kito**

CEO of iMIND Group  
**Bayarsalhan V**

**Moderators & Panelists**

 Founder of Global Institute, Chair of Mongolia FinTech Association <b>Jargalbat D.</b>	 Executive VP, Euronet Group, CEO <b>S. Peter Chok</b>	 Founder and Editor in Chief of FinForum <b>Solon Sidans G.</b>	 Vice-Chairwoman of Information Resources High Level Committee Member <b>Prof. Lee Yanling</b>
 CEO of ICT Group <b>Lihansuren G.</b>	 CEO of ICT Group <b>Sazanir A.</b>	 CEO of Trust Data Korea <b>Han Sang Woo</b>	 CEO of Tenet Fund <b>Lee Jong Chan</b>
 Joint Director of Multilateral Cooperation, Korea Ministry of Science and ICT <b>Koh Young Nam</b>	 CEO of Lendini <b>Gansiga G.</b>	 Chairman of World Finance <b>Salhdarj A.</b>	 Head, Research and Risk Evaluation Division, FIC <b>Khudachalсан N.</b>
 CEO of Mongolia Bank Group <b>Abal Kh.</b>	 COO, Deputy CEO, Euronet.com <b>Salhdarj M.</b>	 Advisor, Supervisor, Govern- ment, Financial Regulatory Commission of Mongolia <b>Bilguun Kh.</b>	 Vice Engineer <b>Datar G.</b>
 General Intelligence Agency of Mongolia for Information Security Department <b>Altankhuyag T.</b>			

Fintech Innovation in Frontier Markets

[www.frontierfintech.org](http://www.frontierfintech.org)



## МЭНДЧИЛГЭЭ

Хатагтай, ноёд та бүхний амар амгаланг эрэн мэндчилье.

Дэлхий нийт өнөөдөр эрчимтэй даяаршиж, эдийн засаг, санхүүгийн салбар техник, технологийн үсрэнгүй дэвшилтэй хоршин асар хурдацтай хөгжиж байгаа нь дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлт, шинэчлэлтүүдийг бий болгож байна. Тэр ч бүү хэл бидний ажил, үүргээ гүйцэтгэх, гэр бүл, найз нөхөд, нийгэмтэйгээ харилцах зэрэг өдөр тутмын амьдралд хүчтэй нөлөөллийг үзүүлж, бид өнөөдөр карт, бэлэн мөнгөний шаардлагагүйгээр төлбөр тооцоогоо хийж, хурууныхаа үзүүрээр л дэлхийн хаанаас ч мөнгө шилжүүлэх боломжтой болсон төдийгүй, хэдхэн жилийн өмнө ямар ч ойлголтгүй байсан электрон түрийвчийг өдөр тутамдаа

өргөнөөр хэрэглэх болсон билээ.

Сүүлийн жилүүдэд финтекийн салбар дахь хөгжүүлэлт, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын хэмжээ эрчимтэй нэмэгдэхийн зэрэгцээ, салбарын хөгжил ч түүнийгээ даган үсрэнгүй хөгжиж байна. Нөгөө талаасаа олон улсын санхүүгийн байгууллага, хөгжлийн нийгэмлэгүүд болон бодлого боловсруулагчид, зохицуулагчдын зүгээс финтекийг санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх гол суваг хэмээн харах болжээ. Блокчэйн, регтек, хэрэглэгчдийг таних дижитал систем, үүлэн систем, хил дамнасан мөнгөн гуйвуулгын платформ, мобайл мөнгө, цахим хэтэвч зэрэг технологийн ололт, дэвшилтүүд нь нийгмийн эмзэг, ядуу бүлгүүд төдийгүй нийт санхүүгийн хэрэглэгчдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг илүү хямд зардлаар, богино хугацаанд, төвөг чирэгдэл багатайгаар хүртэх боломжийг нээж өгч байгаа юм.

Финтекийг зохицуулах зохицуулалтын орчны хэрэгцээ шаардлага гарч ирснээр регтек буюу технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтыг бий болгох хүрээнд зохицуулагч байгууллагууд болон хөрөнгө оруулагчдын зүгээс оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээ тогтмол нэмэгдэж байна. Бизнес, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж эхэлсэнтэй холбогдуулан тэдгээрийн аюулгүй үйл ажиллагаа, өргөжилтийг дэмжсэн, хэрэглэгчдийн эрх ашиг хамгаалагдсан, мэдээллийн аюулгүй байдал хангагдсан зохицуулалтын орчинг бий болгож, хөгжүүлэх, түүнд хүрэх шийдэл гарцаа тодорхойлсон байх учиртай.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс зохицуулалттай этгээдүүдийн тусгай зөвшөөрлийн хүсэлт, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн өргөдөл гомдлыг хүлээн авах цахим платформыг нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хүрээнд эрсдэлийн

үнэлгээний цахим модулийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байгаа билээ. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн хэрэглэгчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, санхүүгийн салбарын мэргэжлийн оролцогчдын тогвортой үйл ажиллагааг дэмжих чиг үүргийнхээ хүрээнд олон улсын хэмжээнд гарч буй зах зээлийн хөгжлийг дэмжихүйц зохицуулалтын арга хэрэгслүүдийг судлах, түүнийг зах зээлд нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Зах зээлд гарч ирж буй шинэ санаачилга, дэвшилтэт бүтээгдэхүүнийг мэдээллийн нэг урсгалаар хянан, зохицуулснаар тэдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний сул тал, эрсдэлийг багасгах, эрх зүйн болон бизнесийн стандарт, шаардлагуудад нийцүүлэх боломжуудыг тооцоолж, финтекийн хөгжилд дэмжлэг үзүүлдэг Сэндбоксыг нэвтрүүлэхээр Хорооны зүгээс ажлын хэсэг байгуулан, холбогдох судалгааг хийж, журам зааврыг батлахаар ажиллаж байна.

2018 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарт л гэхэд давхардсан тоогоор 1.3 сая гаруй харилцагчид санхүүгийн үйлчилгээг технологиор дамжуулан авч байгаа ба салбарын нийт харилцагчдын 80-аас илүү хувь нь дижитал санхүүгийн үйлчилгээг хүртэж, гар утсанд суурилсан зээлийн болон төлбөр тооцооны бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх болсон нь бидэнд финтект суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээний зохицуулалтын орчинг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч буйг бататган харуулж байгаа юм.

Ийм цаг үед Монгол Улсын хувьд бусад улс орнуудын амжилттай хэрэгжүүлж буй туршлагуудыг сайтар судалж, нэвтрүүлэх, зах зээлд оролцогчид болон зохицуулагчдын зүгээс тулгарч буй асуудал бэрхшээлээ хэлэлцэн, шийдэлд хүрэх, хөгжлийн чиг хандлагаа тодорхойлох тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй тул “Фронтейр Финтек Саммит 2019” форум нь цагаа олсон чухал үйл явдал болохыг онцолж байна. Форумыг зохион байгуулагчид, оролцогч та бүхний оролцоо санхүүгийн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр болохыг дурдан, талархал илэрхийлж, цаашдын үйл хэрэгт тань амжилт хүсье.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА  
С.ДАВААСҮРЭН

# МЭНДЧИЛГЭЭ



[www.frontierfintech.org](http://www.frontierfintech.org)  
[www.frontierfintechsummit.org](http://www.frontierfintechsummit.org)  
[contact@frontierfintech.org](mailto:contact@frontierfintech.org)



Мэндчилгээ

ФинТек нь уламжлалт санхүү хийгээд технологийн хөгжлийг хослуулсан гайхалтай салбаруудын нэг бөгөөд уламжлалт банк, даатгалын үйлчилгээний хүртээмж багатай хөгжиж буй зах зээлийг эрэлхийлэн, шилжих чиг хандлага ажиглагдаж байна. Блокчейн, хиймэл оюун ухаан зэрэг сүүлийн үеийн технологи илүү боловсронгуй хэлбэрт шилжин, хөгжиж буй улс орнууд энэхүү технологүүдийг туршин, санхүү, технологийн инновацийг эрчимтэй ашиглаж байна. Энэ нь цаашлаад эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, улс орнуудад олон тэрбум долларын үнэ цэнийг бий болгож байна. Тиймээс ч энэ салбарыг ухаалаг, зохистой зохицуулалтаар удирдан чиглүүлэх, хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна

Санхүүгийн технологийг ашиглан эдийн засгийн хөгжлийг дэмжих нөгөө талаар иргэд, хөрөнгө оруулагчид, улс орны эрх ашгийг хамгаалах зохистой, ухаалаг бодлого зохицуулалтыг уялдуулах нь зайлшгүй шаардлага болон тавигдаж байна. Иймээс бид уламжлалт хийгээд өөрчлөн шинэчлэгдэж буй санхүүгийн байгууллагууд, технологи, бизнесийн салбарын тэргүүлэгчид, эрдэмтэн судлаачид болон төрийн зохицуулалтын байгууллагуудын төлөөллийг оролцуулсан Frontier Fintech Summit арга хэмжээг зохион байгуулж байгаа билээ.

FRONTIER FINTECH SUMMIT-ИЙГ  
ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ

СТЭПП ГРУППЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ГЭРЭЛМАА

14:35-14:55 (20min)	<b>Coffee break</b>			
15:00-16:20	<b>Session 4:</b>	<b>Breaking the banks: future Fintech</b>		
15:00-15:15 (15min)	<b>Keynote speech</b>	P2P	Hyunseo Lim	COO of TANKER FUND
		Branchless banking		
		Credit scoring		
15:15-16:20 (65min)	<b>Panel Discussion</b>		<b>Moderator: Sangwoo</b>	
			Sainbileg	CTO of Golomt bank
			Eugene	Dareum Asset
			Tenuun	Ard Financial Group
			Ken Kodama	Emurgo
16:20-17:40	<b>Session 5:</b>	<b>ICT and Digital Economy Innovation</b>		
16:20-16:35 (15min)	<b>keynote speech</b>		<b>Sangyeol Nam</b>	APEC TEL Chairman
16:35-17:40 (65min)	<b>Panel Discussion</b>		<b>Moderator: Gerelmaa (MC)</b>	<b>CEO of Steppe Group</b>
			Battamir	ICT
			Battumur	Member of Parliament
			Enkhbat	Datacenter
			Youngkyu Lee	Professor
17:40-17:55 (15min)	<b>Closing Keynote</b>	Freezone	<b>Tsogtbaatar Damdin</b>	Minister of Foreign Affairs

			Tsogbaatar D	Minister of Foreign Affairs
			Dagva	City Council
09:25-10:45	<b>Session 1:</b>	<b>Past, Present, Future of Fintech</b>		
09:25-09:40 (15min)	Keynote speech	Payment gateway, 1 click payment	Sangwoo Han	CEO of Truss Chain (Ex. JPM)
		Remittance		
		Virtual accounts		
09:40-10:45 (50min)	<b>Panel Discussion</b>	<b>Moderator: Bayarsaikhan</b>	LendMN	
		Batsaikhan	MongoBank, Payment systems Director	
		Updating		
		Sukhdorj	MostFinance	
		Eduardo Woo	ABC Eagle Capital Brazil	
10min	<b>Q&amp;A</b>			
10:45-11:05 (20min)	<b>Coffee break</b>			
11:05-12:25	<b>Session 2:</b>	<b>Blockchain and the Emergence of Digital Assets</b>		
11:05-11:20 (15min)	Keynote speech	Developing blockchain and shared economy	Charles Hoskinson	Founder of Cardano
		Blockchain deep dive		
		Evolution of Security Tokens & Digital Assets		
		Mortgage and real estate (digitization, financial platform)		
11:20-12:25 (65min)	<b>Panel Discussion</b>	<b>Moderator: Peter</b>	TrussChain	
		Lhamsuren	Jamuha platform, UBEX	
		Altai	Mongolian Stock Exchange	
		Denar	M Lab Singapore	
		Brian	Hong Kong Fintech Assoc.	
10min	<b>Q&amp;A</b>			
12:25-13:15 (50min)	<b>Lunch</b>			
13:15-14:35	<b>Session 3:</b>	<b>Responsible and inclusive finance: tackling challenges with technology</b>		
13:15-13:30 (15min)	Keynote speech	Banking the unbanked	Davaasuren	FRC Chairwoman
		KYC AML		
		Cyber security & risk management		
13:30-14:35 (65min)	<b>Panel Discussion</b>	<b>Moderator: Jargalsaikhan</b>	Defacto	
		Altankhuyag	GIA	
		Updating	Mongolbank	
		Gantulga	Lendmn	
		Gerelmaa	Steppe Group	

12:15-13:15 (60 min)	<b>Lunch</b>			
13:15-15:20	<b>Session 3:</b>	<b>Fintech Ecosystems and Applications</b>		
13:15-13:30 (15min)	<b>Keynote speech 1</b>	Microlending, payment systems and branchless banking	Bayarsaikhan	And Global
13:30-13:45 (15min)	<b>Keynote speech 2</b>	FinTech Trends in Japan	Takeshi Kito	FinTech Association of Japan
13:45-14:35 (50min)	<b>Panel discussion</b>		<b>Moderator: Bolor-Erdene</b>	founder of trends.mn
			Takeshi Kito	FinTech Association of Japan
			Sukhdorj	Chairman of Most Fintech
			Manmeet	Emurgo
14:35-14:45 (10min)			<b>Q&amp;A</b>	
14:45-15:00 (15min)	<b>Coffee break</b>			
15:00-17:00	<b>Session 4:</b>	<b>Managing Risk and Compliance</b>		
15:00-15:15 (15min)	<b>Keynote speech</b>	Preparing today to manage the AML risk of tomorrow	TBU	Mongolbank
		Integrating KYC into the Digital age Audit, risk and regulatory compliance software		
15:15-16:05 (50min)	<b>Panel discussion</b>		<b>Moderator: Peter</b>	<b>Potential Regulatory Model for Mongolia</b>
			Bilguun	FRC, Compliance
			Mandy	Ulaanbaatar office of Minter Ellison
			Cyber securities	CRC
16:05-16:15 (10min)			<b>Q&amp;A</b>	
16:15-16:30	<b>Closing</b>		Gerelmaa	FFS
<i>Theme: Fintech Innovation in Frontier Markets</i>				
<i>Date: May 11, 09:00-18:00</i>				
<i>Venue: Ballroom, Shangrila</i>				
<b>Shangrila, May 11</b>				
08:00-09:00	<b>Registration</b>	<b>Coffee break</b>		
09:00-09:05	Opening	Entertainment		
			Khurelsukh	Prime Minister

Frontier Fintech Summit 2019, Mongolia				
Theme: Fintech Innovation in Frontier Markets				
Subtitle: Policy and Regulation				
Date: May 10, 09:00-18:00				
Venue: MFA				
Agenda				
Time	Topic		Name of Speaker	Job title of Speaker
08:30-09:00	Registration			
09:00-09:15	Opening Remarks		Tsogtbaatar D.,	Minister of Foreign Affairs
			Bulgantuya	Deputy Minister of Finance
			David Soares	Brazilian Congressman
09:15-10:30	Session 1:	Rise of Fintech: Mongolia as a greenfield		
09:15-09:30 (15min)	Keynote speech	Opportunities in Emerging Markets: The Case for Mongolia	Charles Hoskinson (15 min)	Chief Executive Officer at Input Output HK
09:30-10:20 (50min)	Panel discussion		Moderator: Jargalsaikhan	Defacto
			Han Shawn Sangwoo	Truss Chain Korea
			Tsogtbaatar D.,	MFA
			Davaasuren	FRC
10:20-10:30 (10min)	Q&A			
10:30-10:45 (15min)	Coffee break			
10:45-12:40	Session 2:	ICT and Digital Economy Regulations		
10:45-11:00 (15min)	Keynote speech 1	Sandbox Frameworks	Bulgantuya	Deputy MoF
		Further regulatory structures and smart regulations		
		Best practices and case studies		
11:00- 11:15 (15min)	Keynote speech 2	RegTech and Sandbox	Brian W Tang	Hong Kong FinTech Association
11:15-12:05 (50min)	Panel discussion		Moderator: Kherlenchimeg	Truss Chain Management
			Prof.Lee Yonkyu	ChungAng University, APEC
			Sangyeol Nam	APEC TEL Chairman
			Updating	
12:05-12:15 (10min)	Q&A			

## САНХҮҮГИЙН ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ АЮУЛГҮЙ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

Блокчейн тэргүүтэй тархалттай бүртгэлийн технологиуд нь бидний амьдран буй нийгмийг хурдацтайгаар өөрчлөн байгаа билээ. Эдгээр технологиуд дээр суурилсан шинэ аппликэйшнуудын хэрэглээ болон хамрах цар хүрээ нь байнга өргөжин тэлж шинэ салбаруудад эргэлт буцалтгүйгээр нэвтэрсээр байна. Энэхүү хурдацтайгаар өсөж, бизнесийн цоо шинэ боломжуудыг бий болгож буй дэвшилтэт технологийн секторыг зөвөөр бойжуулан үр ашгийг нь хүртэхийн тулд түүнд тохирсон таатай орчинг бий болгох нь зайлшгүй хэрэг юм. Хэрэв Монгол улс зохистой бөгөөд “ухаалаг” бодлогыг бий болгон хэрэгжүүлж чадвал энэхүү шинэ технологи дээр бий болж буй хүчирхэг эдийн засаг, бизнесийг төвлөрүүлэн татсан төв цэг болон хөгжих боломж одоо хэр нь нээлттэй хэвээр.

Энэхүү шинэ технологийг харин хэр хэмжээнд төрийн зүгээс зохицуулан оролцох хэрэгтэй вэ? ICO буюу Initial Coin Offering санхүүгийн шинэ хэрэгсэл болон гарч ирснээс хойш чухам яаж зохицуулах, ямар хууль дүрэмд захирагдах нь тодорхойгүй байв. Учир нь ICO нэг бол зөвхөн төлбөр тооцооны хэрэглээний токен эсвэл хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн (security буюу

хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас)-тай дүйх шинж чанарыг агуулсан байдаг. Хэрэв тухайн токен буюу шинэ крипто мөнгө нь security-н шинжийг агуулсан байвал одоогоор байгаа санхүүгийн түүнд хамаарах хуулиар зохицуулагдах нь зайлшгүй хэрэг бөгөөд энэ нь тухайн токенид хөрөнгө оруулагчдыг гарч болох залилангаас болон бусад санхүүгийн аюулаас хамгаалж буй хэрэг юм. Гэвч нөгөө талаараа тухайн технологийн үндсэн мөн чанарыг алдагдуулан хэт зохицуулалт хийгдсэнээс шинэ боломжуудыг үгүй хийх талтай. Хэдийгээр уг шинэ дижитал технологийн салбарын өгч болох өгөөж нь өндөр ч, нөгөө талаар өндөр эрсдэл дагуулж буй тул Монгол улс хурдан бөгөөд бас аюулгүйгээр нэвтрүүлэх тэр алтан тэнцвэрийг яаж олох вэ?

Дэлхийн хамгийн криптод ээлтэй орон болохоо зарлан түүнийгээ ажил хэрэг болгож буй орон гэвэл Малта. Тэд гурван хууль санаачлан гаргасан бөгөөд ICO-д хянан зохицуулах агентлаг байгуулан үүнтэй хамааралтай хууль бий болгосон хамгийн анхны орон болсон. Энэ ч талаар болоогүй бөгөөд крипто ертөнцийн томчууд болох Binance, OKEx болон BitBay тэргүүтэй бизнесүүд салбараа нээн үйл ажиллагаагаа эрчимтэйгээр явуулж эхлээд буй.

Малтагийн батлан гаргасан гурван хууль Virtual Financial Assests Act (“VFA”) буюу Цахим санхүүгийн хөрөнгийн тухай акт, The Malta Digital Innovation Authority Act (“MDIA”) буюу Малтийн дижитал инновацийн газрын тухай акт, мөн The Innovative Technology Arrangements and Services Act (“TAS” Дэвшилтэт технологи болон түүн дээр суурилсан үйлчилгээний тухай акт) зэрэг болно. Эдгээр хууль актууд нь ICO, хөрөнгийн менежмент, crypto exchange болон түрийвч нь мөн түүнчлэн хөрөнгө оруулагчдыг хамгаалах талаар дэлгэрэнгүй заасан болно.

Бусад ICO-д таатай ханддаг бөгөөд хөхүүлэн дэмждэг орнууд гэвэл мэдээж хэрэг Сингапур болон Швейцар улсууд. Тэд аль хэдийн маш өндөр төвшинд хөгжсөн хөрөнгө санхүүгийн зах зээлтэйн дээр тэдгээрийг зохицуулах жишиг хууль, заалттай байдаг. Тэд блокчейн болон бусад шинэ технологийг шинээр нэвтрүүлэхдээ “Fintech Regulatory Sandbox” -г ашигладаг бөгөөд энэхүү бодлогын хэрэглэгдэхүүн нь “Эдийн засагт өндөр үр нөлөө бүхий санхүүгийн дэвшилтэт технологиудыг туршин хөгжүүлэх таатай орчныг нь төрөөс бүрдүүлэн өгч бизнесийн эрсдэлийг нь багасгах мөн тухайн шинэ технологид тохирсон бодлогын загварыг шинээр бий болгох” гэсэн үндсэн зорилготой байна. Мөн Швейцар улс нь Crypto Valley буюу Крипто Хөндийг үүсгэн байгуулж “Ухаалаг бодлого” мөн санхүүгийн таатай орчныг бий болгон Европын болоод дэлхийн крипто инновацийн төв болохоор ажиллаж байгаа билээ.

Эдгээр жишээнээс харахад ICO-д хамааралтай одоогоор хэрэгжиж буй болон шинээр бий болох хууль, тэдгээрийн зохицуулалтыг анхнаас нь оновчтойгоор зөв чиглэлд нь залах төрийн агентлаг байх нь зайлшгүй хэрэгцээтэй болж байна. Мэдээж төрийн зүгээс мөнгө угаалтын эсрэг мөн терроризмын санхүүжилтийн эсрэг олон улсын хууль, тогтоомжуудад нийцүүлэн хамгийн аюулгүй бөгөөд ард иргэддээ массыг хамарсан крипто нэр барьсан залилангуудаас сэргийлэх нь зүй ёсны хэрэг юм. Хэрэв Монгол Улс ICO нь зөв зохицуулалтыг дээрх шалгууруудад нийцүүлэн хийж чадвал илүү бодит мөн чадварлаг олон улсын компаниуд итгэл төгс Монгол улсад шинээр салбараа нээн бизнесээ өргөжүүлэх үүд хаалга бүрэн нээгдэх нь дамжиггүй.

ICO болон блокчейнийг зохицуулах тодорхой мөн оновчтой хуульгүйгээс олон дэвшилтэт санаанууд ажил хэрэг болж чадалгүй үлдсэн байдгийн нэг жишээ нь Black Cell Technology Limited (Black Cell) бөгөөд Хонг Конгийн security-н хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжгүй гэсэн шалтгаанаар хаалга барьсан билээ.

Асуудлын гол нь гэвэл Монгол Улс бусад орны хуучинсаг чигийг даган хэт зохицуулалт хийх

үү эсвэл Сингапур мэт орны сайн жишээг даган өөрсдийн “Sandbox”-г бий болгон нухацтайгаар зөв зохицуулалт хийх үү гэдэг л байгаа юм. АНУ ч бас Jumpstart Our Business Startup Act-г санаачлан шинэ дэвшилтэт санаа болон бизнесүүдийн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад нь төрийн зүгээс дэмжлэг үзүүлэн зарим тохиолдолд хуулиас чөлөөлөгдөх практик бий.

Бидний өмнө гарч ирээд буй энэхүү шинэ боломжийг бид яаж алдахгүй авч ашиглах вэ? Одоо л бид үүнийг барьж авах цаг. 2018 оны 2 дугаар сар гэхэд 53 амжилттай хэрэгжсэн ICO байна. Үүнд бид амжилттай гэдгээр бид 10 сая доллароос дээш хөрөнгө босгосон, тогтвортойгоор үйл ажиллагаагаа явуулж буй бөгөөд ямарваа нэгэн хууль зөрчөөгүй гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэсэн бөгөөд аль оронд үйл ажиллагаа явуулж байгааг нь жагсаавал:

1. Сингапур: 11
2. Швейцар: 10
3. Кайманы арлууд: 7
4. АНУ: 6
5. Их Британи: 3

Сингапур болон Швейцар орнууд нь чанартай ICO-н тоогоороо тэргүүлж байгаа бөгөөд зөв ухаалаг бодлоготой нь салшгүй холбоотой. Бид ч гэсэн хурдацтайгаар өсөн нэмэгдэж буй энэ шинэ зах зээлд оновчтой бодлого хэрэгжүүлэн оролцох боломж бүрэн нээлттэй байгаа бөгөөд давхар эдийн засгийн аюулгүй байдлаа хангах боломж бий юм. Зөв ICO-г сонгон жишиг болгон “Sandbox”-т шалгаруулан оруулснаар бид эдийн засаг болоод эрх зүйн өндөр хариуцлагатай бодлого явуулж чаддаг бөгөөд блокчейн болон бусад дэвшилтэт технологийг чухлаар авч үзэн ач холбогдлыг нь үнэлж буйгаа дэлхийд харуулж чадах бөгөөд олон олон бизнесүүд Монголыг тэр үед зорин ирэх болно.